



**"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 21/02

Чойбалсан хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59.4, 59.10, 59.11, 60, 67, 71, 76 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", "Адуунчулуун" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Адуунчулуун" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14:00 цагт Дорнод аймаг, Хэрлэн сум, 8-р баг, "Адуунчулуун" ХК-ийн хурлын танхимд хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй. Үүнд:

- A. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
- B. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
- C. ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах
- D. ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг батлах
- E. ТУЗ-ийн гишүүдийг сонгох /СЗХорооны 2020 оны 880-р тогтоолоор баталсан Санал хураах кумулятив аргаар/

Хоёр. Хурал хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад мэдэгдэх хугацааг 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн хугацааг 2021 оны 04 дугаар сарын 05-ны өдрөөр тогтоосугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга, загварыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдөр буюу 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 15<sup>00</sup> цагийн дотор, мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчээс санал хүлээн авахаар тогтсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын 02 дугаар хавсралтаар баталж Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын сонинд 2021 оны 03 дугаар сарын 18 -ны өдөр тус тус нийтлүүлэхийн зэрэгцээ давтан зарыг 04 дүгээр сарын 02-нд өдөр тутмын /өдрийн сонин, зууны мэдээ/ болон орон нутгийн сонин /Дөл, Дорнод/ радио, телевиз /Мижи, ТВ6, Дорнод ТВ/-д тус тус мэдээлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг зохион байгуулах комисст даалгасугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 03 дугаар хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 04 дүгээр хавсралтад заасан бичиг баримттай 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл 08<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд "Адуунчулуун" ХК-ийн байранд ирж танилцах, имэйлээр авах эсвэл харьяалагдах Үнэт цаасны компаниас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Баттогтох овогтой Шатар /ТУЗ-ийн дарга/-ыг томилж, тооллогын комисс болон зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг 05 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 06 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай" журмын дагуу хурлын зарыг хүргэж, хурлыг бэлтгэл сайтай явуулахыг хурал зохион байгуулах комисс, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Гангамөрөн нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР